

БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар цэцэрлэг нь Улаанбаатар хотын АДХГЗ-ны 140 дүгээр тогтоолоор 1986 оны 07 дугаар сарын 03-ны өдөр 280 хүүхдийн хүчин чадалтай, 12 бүлэгтэй, 39 ажилчидтайгаар үүсэн байгуулагдсан. Цэцэрлэгийн анхны эрхлэгчээр С.Зоригт 1986-1990 он хүртэл ажилласан. Дүгэрдулам 1990-1994, Батцагаан 1994-1995 онуудад, Т.Байгаль 1996 оноос одоог хүртэл нар тус цэцэрлэгийн эрхлэгчээр томилогдон ажиллаж байна.

Цэцэрлэгийн 10 жилийн ойг 1996 оны 11-р сарын 23-нд тэмдэглэж өнгөрүүлсэн бөгөөд ойн арга хэмжээнд дүүргийн нийт цэцэрлэгийн эрхлэгч нар, Дүүргийн Засаг дарга Л.Найдан, Боловсролын хэлтсийн мэрэгжилтэн Анхтуяа, шефь байгууллагын удирдлагууд, Эрдэнэтийн 4-р цэцэрлэгийн эрхлэгч багш нарын төлөөллүүд, тус цэцэрлэгийн ахмадууд зэрэг зарим байгууллагын хүмүүс урилгаар оролцуулж байжээ. Мөн ойн арга хэмжээн дээр цэцэрлэгийн нийт багш ажилчдыг шагнаж урамшуулсан ба дуу хөгжмийн багш Ц.Энхтайван АБТА цол тэмдгээр шагнагдсан.

Байгууллагын ажлын амжилт:

№	Он	Ажлын амжилт
1	1997	СХД-ийн тэргүүний цэцэрлэг
2	1998	СХД-ийн тэргүүний цэцэрлэг
3	2002	СХД-ийн тэргүүний цэцэрлэг
4	2003	СХД-ийн тэргүүний цэцэрлэг
5	1998	Нийслэлийн тэргүүний цэцэрлэг
6	1998	Хэрэглэгчдийн найдвартай түнш байгууллага
7	2003	Нийслэлийн тэргүүний Өмч эзэмшигч байгууллага
8	2004	СХД-ийн Манлай цэцэрлэг
9	2004	Нийслэлийн Шилдэг менежменттэй цэцэрлэг
10	2005	Эрүүл мэндийн дэмжигч байгууллага
11	2005	Клиник цэцэрлэг
12	2005	Нийслэлийн тэргүүний цэцэрлэг
13	2007	Хүүхдийн хоолны мөнгө хураалт, тушаалтаар “Өргүй тэргүүний байгууллагааар” шалгарч дүүрэгт 1-р байр эзэлсэн.
14	2008	Улсын тэргүүний цэцэрлэг
15	2010	Нийслэлийн тэргүүний “Өмч эзэмшигч” байгууллага
16	2010	Шилдэг Үйлдвэрний Эвлэлийн бүлэг
17	2010	СХД-ийн “Оны шилдэг байгууллага”
18	2013	НХЦ-ийн “ Шилдэг үйлдвэрчний эвлэлийн бүлэг “

Багш нарын амжилт бүтээлээс:

Ур чадварын уралдаан

1994 онд Ц.Энхтайван дүүрэгт дүүрэгт 1-р байр, хотод 2-р бар, улсад тусгай байр

1999 онд Д.Цэрэндулам дүүрэгт 1-р байр ,нийслэлд тусгай байр

2006 онд Д.Цэрэндэжид дүүрэгт 3-р байр

2007 онд П.Батчимэг дүүрэгт 1-р байр, нийслэлд 5-р байр тус тус эзэлж байсан.

2010 онд Д.Төгсөө СХД-ийн Мэрэгжлийн аварга багш

2012 онд П.Долгормаа СХД-ийн залуу аварга багш

Нийслэл, дүүргийн хэмжээнд үзүүлсэн багш нарын амжилт

Амжилт бүтээл

1999 онд Ц.Энхтайван “Нийслэлийн шилдэг залуу багш”

2002 онд Ц.Батцэцэг СХД-ийн “Тэргүүний бүлэг”-ээр шалгарсан

2003 онд Ц.Батцэцэг “Нийслэлийн оны тэргүүний багш”-аар шалгарсан.

Бүсгүйчүүд тэмцээн

2007 онд Д.Идэржаргал дүүрэгт 1-р байр, хотод тусгай байр НХЦҮЭХ-ны хүндэт өргөмжлөлөөр шагнагдсан.

Нийслэлийн цэцэрлэгүүдийн дуу хөгжмийн болон , бүлгийн багш, арга зүйч нарын дунд зохион явуулсан үзүүлэх ажил.

2013 оны 1 сард “Хөгжмийн хичээлд техник хэрэгслэлийг ашиглах нь” түүний ач холбогдол : сэдвээр дуу хөгжмийн багш Д.Төгсөө үзүүлэх нээлттэй ажил зохион явуулж нийт 100 гаруй багш нар оролцон талархлаа илэрхийлсэн.

2013 оны 5- сард . Хөгжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан “Хүүхдийн оюун сэтгэхүйг” хөгжүүлэх нь: сэдвээр дүүргүүдийн цэцэрлэгийн зарим арга зүйч, сургагч багш нарт багш Б.Цогзолмаа нээлттэй үзүүлэх ажил, багш Д.Цэрэндэжид хөгжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан “Хүүхдийн гарын жижиг булчинг “ хөгжүүлэх нь: үзүүлэх ажлыг тус тус явуулж тэднээс өндөр үнэлэлт авсан.

Хоёр. Хөмрөгийн баримтын түүх

Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар цэцэрлэг нь Нийслэлийн Боловсролын газарт 1986-1999 оны байнга хадгалах 14 ХН шилжүүлж байсан ба төрийн архивт 182 тоот хөмрөг үүсгэсэн.

Тус байгууллага нь 2013 онд 2000-2012 оны байнгын баримтаар Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу нөхөн бүрдүүлэлт хийхээр нярав, архив ажилтан Д.Мөнхцэцэг миний бие нийслэлийн Архивын газрын зааварлагч, арга зүйч Н.Цацралтуяагаас мэргэжил арга зүйн зааварчилгаа аван байгууллагын архивт хадгалагдаж буй 1986-2012 оны архивын баримтад 2013 оны 12 дугаар сарын 06-наас 2014 оны 03 дугаар сарын 06-ныг дуустал хугацаанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Баримтын бүрдэл:

Байнга хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: Эрхлэгчийн тушаал, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, биелэлт, хичээлийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан,

СӨБ-ын мэдээ, тайлан, ирсэн, явуулсан бичиг, санхүүгийн жилийн эцсийн тайлан тэнцэл, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна.

70 жил хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: Цалингийн карт, цалингийн тооцооны хүснэгт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны хуудас, Эрхлэгчийн “Б” тушаал, зэрэг баримтуудаас бүрдэж байна. Цалин 1986-2012 хүртэл, дутуу он 1993 он, НДШ төлөлтийн тооцооны хуудас 2001-2012 хүртэл, эрхлэгчийн “Б” тушаал 2008-2012 хүртэл бүрэн бүрдэлтэй.

Түр хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл, сар, улирлын төлөвлөгөө, тайлан, ажилтнуудын төлөвлөгөө, тайлан, хөдөлмөрийн гэрээ, хүүхдийн дэлгэрэнгүй бүртгэл, гомдол, бэлэн мөнгөний орлого, зарлага, касс, харилцах, цалингийн баримтууд, хүүхдийн хоолны мөнгөний тооцоо, няравын тайлан, аж ахуйн гэрээ, санхүүгийн улирлын тайлан тэнцэл, үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна.

ЭШТБ-ын ажлын явцад:

1. 2000-2012 оны баримтуудыг нягтлан шалгаж, ангилан ялгаж, эрхлэгчийн тушаалыг 2008 оноос үйл ажиллагааны болон боловсон хүчний асуудлаар 2 ангилан он, сар, өдрийн дараалалд оруулж, хуудас дугаарлах, үдэж хавтаслах, нуруу цаас наах, нүүр бичилт хийх зэрэг техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2. 2008 оноос ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлыг ач холбогдол, хадгалах хугацаагаар нь байнга, түр болгож ангилан, хэрэг бүрдүүлж авсан.

3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдээс тухайн жилд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын жилийн төлөвлөгөө, тайлан, холбогдох баримтуудыг байнга салган авч, сар, улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан мэдээг түрд үлдээв.

4. Санхүүгийн тайлан тэнцэл, татварын тайлан, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан зэрэг нь санхүүгийн баримтад хамт үдэгдсэн байсныг /баримтын шалгалтад орсон тул удирдлагын зөвшөөрөлтэйгээр задласан/ 2008 он хүртэл ялгаж холбогдох баримтуудыг авсан бөгөөд 2009 оноос хойшихийг задлалгүй түрийн бүртгэлд нь үлдээв.

5. 2003 оноос өмнөх касс, харилцахын баримт, хүнс материалын тайлан, хүүхдийн хоолны мөнгөний тооцоо, үндсэн хөрөнгө, эд хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл, мөн хадгалах хугацаа дууссан удирдлагын баримт бичгүүдийг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 7 хэргийн 30 ХН-д устгах хэргийн акт үйлдсэн.

6. Архивын газрын сан хөмрөгт хадгалагдаж буй тус цэцэрлэгийн 1987-1999 оны байнга хадгалах 11 ХН бүхий данстай данс нэгтгэж, 1987-2012 оны 106 ХН бүхий 182/2/15

тоот данс үйлдэв. 1987-2009 байнга хадгалах баримтыг төрийн архивт шилжүүлэх, 2010-2012 оны байнга хадгалах баримтын дансыг хурлаар батлуулж баримтыг байгууллагын архивт үлдээхээр шийдвэрлэв.

ЭШТБ-ын ажлын үр дүнд:

- 1987-2009 оны 81 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2010-2012 оны 25 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2003-2012 оны 92 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1986-2012 оны 46 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 1996-2010 оны 13ш зураг бүхий 1 CD гэрэл зургийн баримтын бүртгэл,
- 2010-2011 оны 2 CD бүхий дүрс бичлэгийн баримтын бүртгэл,
- 2000-2010 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 7 нэр төрлийн 30 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдэв.

Дээрх данс, бүртгэл, актыг Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар цэцэрлэгийн дэргэдэх БНШК-ийн 2014 оны 03 дүгээр сарын 10-ны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ ҮЙЛДСЭН:
НЯРАВ, АРХИВ АЖИЛТАН

Д.МӨНХЦЭЦЭГ